

Батхаан уулын байгалийн нөөц газар

Хамгаалалтанд авсан үндэслэл

Батхаан уул нь Төв аймгийн Эрдэнэсант, Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт орших бөгөөд байгалийн үзэсгэлэнт байдлыг харгалзан 1957 оны АИХ-ийн Тэргүүлэгчдийн 31 дүгээр зарлигаар дархан цаазат газар болгосон ч байгалийн муж, ландшафтын нийтлэг төрхийг төлөөлж чадахгүй байгааг харгалзан Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолоор ангиллыг өөрчилж байгалийн нөөц газар болгосон байна. Нийт талбайн хэмжээ 21850га.

Газарзүйн онцлог

Батхаан уул нь Хангай Хэнтийн уулархаг мужид багтах ба Орхон, Туулын савын 1500-2000м өргөгдсөн бэсрэг өндөр уулсын нэг бөгөөд Монгол орны хамгийн өмнөд захын ой бүхий уул юм. Энд Хангайн гол нурууны хамгийн дорнод төгсгөл, зүүн үзүүр болох Дэлгэр хан, Батхаан, Үст буурал, Аргаль, Угалз гурван өндөр, Уулын хөшөөт, Ботгон царам зэрэг нэгэн их бөөгнөрсөн тарамцаг оршино. Баруун хойш, зүүн урагш чиглэн үргэлжилсэн Батхааны нурууны хамгийн өндөр оргил Батхаан 2178 м өргөгджээ.

Эрт төрмөлийн болон дунд төрмөлийн эриний үед өргөгдөн үүссэн ба энд эрт төрмөлийн дунд үеийн хувирмал элсэн чулуу, хувирмал занар, аргиллит, ланцар, гантиг, гөлгөр, мөлгөр хөрзөн гэх мэт асар их хувирсан хурдас чулуулаг хийгээд маш зузаан хүчиллэг чулуулаг зонхилно.

Батхаан уул жинхэнэ хээр, уулт хээрийн бүсэд орших учир нийт нутгаар үржил сайтай, хар ба хүрэн хөрс зонхилно. Ар, өвөр Жаргалант голын хөндийгөөр элсэнцэр, болон жинхэнэ элсэн хөрстэй, ар өврөөр гол горхи олонтой. Жаргалантын адагт Хирд Дэвсэн булаг, Хунхар гэх мэт эрдэст рашаантай.

Батхаан уулын Өвөр, Ар Жаргалант, голын бүх хөндийгөөр манхан элстэй бөгөөд энэ элс зүүн урагшаа шууран нүүж Өвөр Жаргалант голын хөндийн урд ар, дунд хэсгийг дарсаар байна.

Амьтны аймаг

Батхаан нь ан амьтнаар баялаг биш боловч буга, бор гөрөөс, гахай, шилүүс, мануул, үнэг, хярс, чоно, туулай, тарвага, зурам зэрэг хээрийн амьтадтай.

Ургамлын аймаг

Батхааны ууланд ойт хээр, уулын хээр зонхилсон тул ургамлаар нэн баялаг. Тус орны хамгийн өмнөд захын ой модтой уулын нэгэнд Батхаан орно. Энд хус, хуш, улиангар бүхий хэсэг хэсэг ойтой. Үүнд цагаан хустай ой голлоно. Гурван зүйлийн навчит ойгоос гадна уулын энгэр хад асга, хоолой жалга ганга хавцлаар хайлаас мэр сэр байдаг. Уулын ар хэсгээр хусан торлог голлон ургасан цардуултай газар олон бий. Батхааны нуруунд ерхөг, хялгана, хиаг, согоовор, ботуул, морины уруул шувуун хөл, өлөн, агь зэрэг бэлчээрийн нарийн өвс ургамлаас гадна бамбай, сөд, дэгд, башир, алтан гагнуур, тарваган шийр, ганга гэх мэтийн эмийн ургамал элбэгтэй. Хүнсэнд хэрэглэдэг ургамлаас цагаан төмс, мэхээр, цагаан мангир, мойл бий.

Түүх соёл

Уулын өвөр хормой, ар өвөр Жаргалант голуудын хойд дэнж, уулын ар хормой, арын олон гол горхийн ам хөндийгөөр түүхий дурсгал болох эртний булш, хиргисүүр

олон бий. Эдгээрээс гадна Бичигтийн амны хадан бичиг, Тогоот уулын Хаданд тогоо, Хуягтад хөө хуяг тус тус байна. Үүнээс нутгийн хүмүүс дээр үеэс хуягтын хөө хуягаас авч шагайн сум хийсээр байгаад дууссан байна. Тогоот улаан хадны тоог 1973 онд Эрдэнэсант сумын музейн үзмэрт тавьжээ. Өвөр Жаргалан голын адаг орчмын Сайжрах гэдэг газрын зузаан, ноцох занар, элсэн чулуу, мөлгөр, хөрзөн зэрэг цэрдийн хурдаст чулуулаг болон Батхааны өврийн Лүнгийн хөх, Хөх даваа зэрэг газруудад аварга гүрвэлийн мөрний хэв, аварга гүрвэлийн чулуужсан яс хийгээд дөрөвдөгч галвын хурдас чулуулагт арслан зааны яс тус тус бий бөгөөд тэр мөрнөөс Улсын төв музейд тавьжээ.

Эх сурвалж: Оюунгэрэл.Б. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг.УБ.2004

Мэдээллийг бэлтгэсэн: МУИС Экологи-2 Э.Өгөөмөр

Харилцах хаяг : Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн
Монгол дахь хөтөлбөрийн газар

Web site: www.wwf.mn www.econet.mn
E-mail: info@wwf.mn

2009.03.12